



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД — 2020

Улаанбаатар хот
2021 он





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2020 ОНД

Улаанбаатар хот
2021 он

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Э.Мягмарханд,

ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын, Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга

Х.Тэмүүлэн,

ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын гэрээт ажилтан

Танилцуулгыг хянасан:

Б.Батдаваа,

ҮСХ-ны дарга

Э.Эрдэнэсан,

ҮСХ-ны Нэгдсэн статистикийн газрын дарга

Д.Энхмаа,

ҮАБЗ-ийн ажлын албаны СБДШМГ-ын дүн шинжилгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Хаяг: Засгийн газрын III байр, Улаанбаатар-20а, Монгол Улс

Утас: 11-326414, 51-261563, 1900-1212

Имэйл: information@nso.mn, Веб хаяг: www.nso.mn, www.1212.mn.

АГУУЛГА

ОРШИЛ.....	5
НЭГ. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	6
ХОЁР. ХҮНСНИЙ ХҮРТЭЭМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	10
ГУРАВ. ХҮНСНИЙ ИЛЧЛЭГ ШИМ ТЭЖЭЭЛ	14
ДӨРӨВ. ХҮНСНИЙ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	15
ТАВ. ДҮГНЭЛТ	22
ХАВСРАЛТ 1. Тооцоололд ашигласан итгэлцүүр, норм, стандарт	23
ХАВСРАЛТ 2. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮТХ	Үндэсний тооцооны хэлтэс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЦАБШХТ	Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоо

ОРШИЛ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь манай улсад хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалтын шинэ орчныг бий болгосон.

Эдгээр баримт бичигт хүнсний аюулгүй байдлын тухай ойлголт, тодорхойлолтыг тодорхой тусгаж өгсөн.

Үндэсний Статистикийн Хорооны даргын 2015 оны А/12 тоот тушаалаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлснээр хүнсний аюулгүй байдлын түвшинг тодорхойлж, нийгмийн эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын чиглэлийг боловсруулахад нэн шаардлагатай статистикийн мэдээлэлтэй болсон.

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг хүнсний хангамж; хүнсний хүртээмж; хүнсний илчлэг, шим тэжээл; хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн дөрвөн хэсэгт хуваан танилцуулгыг бэлтгэв.

Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хангамж, хүртээмж, хэрэглээ болон тогтвортой байдалд дүгнэлт хийж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга материал, суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

НЭГ. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний хангамжийг улсын хэмжээнд тодорхойлохдоо тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулна.

ЭМЯ-ны Хоол судлалын төвөөс тогтоосон дараах гол нэр төрлийн 16 бүтээгдэхүүнийг хамруулж хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцлоо. Үүнд: мах, махан бүтээгдэхүүн; сүү; сүүн бүтээгдэхүүн; гурил; гурилан бүтээгдэхүүн; төрөл бүрийн будаа; сахар, чихрийн зүйл; төмс; хүнсний ногоо; буурцагт ургамал; жимс, жимсгэнэ; өндөг; ургамлын тос; цөцгийн тос зэрэг бүтээгдэхүүн орно.

1. Жишсэн хүн ам. Монгол Улсын жилийн эцсийн суурин хүн амын тоо 2020 онд 3253.3 мянга, жишсэн хүн амын тоо 2630.0 мянга болж, суурин хүн амын тоо өмнөх оноос 56.3 мянган хүн буюу 1.8 хувиар, жишсэн хүн амын тоо өмнөх оноос 46.5 мянган хүн буюу 1.8 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО


	2017	2018	2019	2020*	2020/2019	
	мянган хүн				Зөрүү	Хувь
Суурин хүн амын тоо	3 131.8	3 186.3	3 197.0	3 253.3	56.3	1.8
Жишсэн хүн амын тоо	2 540.7	2 577.2	2 583.5	2 630.0	46.5	1.8

* ҮСХ-ын тооцоолол.

Тайлбар: Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар шинэчлэгдсэн.

2. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ. Манай улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, улсын хэмжээнд жилд нийтдээ 182.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 153.6 мянган тонн сүү, 172.8 мянган тонн сүүн бүтээгдэхүүн, 96.0 мянган тонн гурил, 172.8 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 48.0 мянган тонн будаа, 31.7 мянган тонн сахар, чихрийн зүйл, 115.2 мянган тонн төмс, 249.6 мянган тонн хүнсний ногоо, 38.4 мянган тонн буурцагт ургамал, 192.0 мянган тонн жимс, жимсгэнэ, 19.2 мянган тонн өндөг, 22.1 мянган тонн ургамлын тос, 9.6 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна (Хүснэгт 2).

Зураг 1. ЖИШСЭН ХҮН АМЫН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭ, мянган тонн



Жишсэн хүн амын хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ өмнөх оноос 0.2-4.4 мянган тонноор нэмэгдсэн байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, хүнсний ногооны хэрэгцээ 2.7-4.4 мянган тонноор нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлттэй байна.

ХҮСНЭГТ 2. ЖИШСЭН ХҮН АМЫН ЖИЛИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭ

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний хүнсний жилийн хэрэгцээ	Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ			
		2017	2018	2019	2020*
	килограмм	мянган тонн			
Мах, махан бүтээгдэхүүн	69.4	176.2	178.7	179.2	182.4
Малын мах	43.8	111.3	112.9	113.2	115.2
Загас	11.0	27.8	28.2	28.3	28.8
Шувууны мах	14.6	37.1	37.6	37.7	38.4
Сүү	58.4	148.4	150.5	150.9	153.6
Сүүн бүтээгдэхүүн	65.7	166.9	169.3	169.7	172.8
Гурил, гурилан бүтээгдэхүүн	102.2	259.7	263.4	264.0	268.8
Гурил	36.5	92.7	94.1	94.3	96.0
Гурилан бүтээгдэхүүн	65.7	166.9	169.3	169.7	172.8
Төрөл бүрийн будаа	18.3	46.4	47.0	47.1	48.0
Төмс	43.8	111.3	112.9	113.2	115.2
Хүнсний ногоо	94.9	241.1	244.6	245.2	249.6
Буурцагт ургамал	14.6	37.1	37.6	37.7	38.4
Жимс, жимсгэнэ	73.0	185.5	188.1	188.6	192.0
Өндөг	7.3	18.5	18.8	18.9	19.2
Ургамлын тос	8.4	21.3	21.6	21.7	22.1
Цэцгийн тос	3.7	9.3	9.4	9.4	9.6
Сахар, чихрийн зүйл	12.0	30.6	31.0	31.1	31.7

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

3. Дотоодын үйлдвэрлэл. Дотоодод 2020 онд улсын хэмжээнд 1 сая тонн сүү, 649.1 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 244.3 мянган тонн төмс, 235.3 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 126.5 мянган тонн сахар, чихрийн зүйл, 121.2 мянган тонн хүнсний ногоо, 8.5 мянган тонн өндөг, 1.6 мянган тонн жимс, жимсгэнэ, 0.2 мянган тонн цэцгийн тос үйлдвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 3. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, биет хэмжээгээр, тонн

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2019		2020*		Өсөлт, бууралт, %
	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	
Мах, махан бүтээгдэхүүн	488 343.4	39 059.0	649 121.1	20 664.6	32.9
Малын мах	487 843.1	39 028.7	648 548.8	20 630.9	32.9
Загас	30.3	30.3	33.7	33.7	11.1
Шувууны мах	470.0	0.0	538.7	0.0	14.6
Сүү	956 767.8	0.0	1 004 998.2	0.0	5.0
Сүүн бүтээгдэхүүн	117 466.3	30.8	77 390.2	481.0	-34.1

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	2019		2020*		Өсөлт, бууралт, %
	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	Дотоодын үйлдвэрлэл	Экспорт	Дотоодын үйлдвэрлэл
Гурил, гурилан бүтээгдэхүүн	209 370.4	111.9	235 286.1	20.3	12.4
Гурил	164 384.3	5.0	191 120.9	0.2	16.3
Гурилан бүтээгдэхүүн	44 986.1	106.9	44 165.2	20.1	-1.8
Төрөл бүрийн будаа	0.0	0.0	0.0	0.0	-
Төмс	192 239.9	0.0	244 261.6	0.0	27.1
Хүнсний ногоо	99 546.6	16.8	121 235.1	84.0	21.8
Буурцагт ургамал	54.3	0.0	19.6	0.0	-63.9
Жимс, жимсгэнэ	1 863.8	30.7	1 665.4	33.6	-10.6
Өндөг	8 937.0	0.0	8 482.5	0.0	-5.1
Ургамлын тос	263.8	4.1	17.2	0.0	-93.5
Цэцгийн тос	203.9	2.0	250.0	0.3	22.6
Сахар, чихрийн зүйл	112 976.6	43.6	126 451.5	37.5	11.9

Эх үүсвэр: ҮСХ, ГЕГ, * Урьдчилсан гүйцэтгэл

4. Хэрэглээ. Хүн амын хэрэгцээнд 2020 онд улсын хэмжээнд 1 сая тонн сүү, 647.8 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 262.6 мянган тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, 244.3 мянган тонн төмс, 199.5 мянган тонн хүнсний ногоо нийлүүлсэн байна.

ХҮСНЭГТ 4. ХЭРЭГЛЭЭ, биет хэмжээгээр, мянган тонн

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Хэрэглээ		Дотоодын үйлдвэрлэлээс		Импортоос	
	2019	2020*	2019	2020*	2019	2020*
Мах, махан бүтээгдэхүүн	466.6	647.8	449.3	628.5	17.3	19.3
Малын мах	450.1	629.4	448.8	627.9	1.2	1.5
Загас	2.9	2.8	0.0	0.0	2.9	2.8
Шувууны мах	13.7	15.6	0.5	0.5	13.2	15.1
Сүү	956.9	1 005.1	956.8	1 005.0	0.1	0.1
Сүүн бүтээгдэхүүн	169.4	126.3	117.4	76.9	52.0	49.4
Гурил, гурилан бүтээгдэхүүн	236.9	262.6	209.3	235.3	27.6	27.4
Гурил	168.8	194.5	164.4	191.1	4.4	3.4
Гурилан бүтээгдэхүүн	68.1	68.2	44.9	44.1	23.2	24.0
Төрөл бүрийн будаа	45.2	56.4	0.0	0.0	45.2	56.4
Төмс	192.6	244.3	192.2	244.3	0.4	0.0
Хүнсний ногоо	177.7	199.5	99.5	121.2	78.2	78.3
Буурцагт ургамал	0.1	0.0	0.1	0.0	0.0	0.0
Жимс, жимсгэнэ	54.5	45.8	1.8	1.6	52.6	44.1
Өндөг	17.0	16.6	8.9	8.5	8.0	8.1
Ургамлын тос	12.7	16.4	0.3	0.0	12.5	16.4
Цэцгийн тос, 72% тослогтой	0.4	0.5	0.2	0.2	0.2	0.3
Сахар, чихрийн зүйл	177.2	192.6	112.9	126.4	64.2	66.2

Эх үүсвэр: ҮСХ, ГЕГ

* Урьдчилсан гүйцэтгэл

5. Хүнсний хангамжийн түвшин. Хүнсний хангамжийн түвшинг өмнөх онтой харьцуулахад мах, махан бүтээгдэхүүнийх 94.8 нэгж хувь, төмснийх 41.8 нэгж хувь, сахар, чихрийн зүйлийнх 38.8 нэгж хувь, төрөл бүрийн будааных 21.5 нэгж хувь, сүүнийх 20.2 нэгж хувь, ургамлын тосных 15.5 нэгж хувь, гурил, гурилан бүтээгдэхүүнийх 8.0 нэгж хувь, хүнсний ногооных 7.4 нэгж хувь, цөцгийн тосных 0.9 нэгж хувиар тус тус өссөн бол сүүн бүтээгдэхүүнийх 26.7 нэгж хувь, жимс, жимсгэнийнх 5.1 нэгж хувь, өндөгнийх 3.4 нэгж хувь, буурцагт ургамлынх 0.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 5. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ТҮВШИН, хувиар

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ		Хэрэглээ		Хангамжийн түвшин	
	2019	2020*	2019	2020*	2019	2020*
	мянган тонн				хувь	
Мах, махан бүтээгдэхүүн	179.2	182.4	466.6	647.8	260.4	355.2
Малын мах	113.2	115.2	450.1	629.4	397.7	546.4
Загас	28.3	28.8	2.9	2.8	10.1	9.6
Шувууны мах	37.7	38.4	13.7	15.6	36.3	40.6
Сүү	150.9	153.6	956.9	1 005.1	634.2	654.4
Сүүн бүтээгдэхүүн	169.7	172.8	169.4	126.3	99.8	73.1
Гурил, гурилан бүтээгдэхүүн	264.0	268.8	236.9	262.6	89.7	97.7
Гурил	94.3	96.0	168.8	194.5	179.0	202.6
Гурилан бүтээгдэхүүн	169.7	172.8	68.1	68.2	40.1	39.4
Төрөл бүрийн будаа	47.1	48.0	45.2	56.4	95.9	117.4
Төмс	113.2	115.2	192.6	244.3	170.2	212.0
Хүнсний ногоо	245.2	249.6	177.7	199.5	72.5	79.9
Буурцагт ургамал	37.7	38.4	0.1	0.0	0.2	0.1
Жимс, жимсгэнэ	188.6	192.0	54.5	45.8	28.9	23.8
Өндөг	18.9	19.2	17.0	16.6	90.0	86.6
Ургамлын тос	21.7	22.1	12.7	16.4	58.8	74.3
Цөцгийн тос, 72% тослогтой	9.4	9.6	0.4	0.5	4.5	5.4
Сахар, чихрийн зүйл	31.1	31.7	177.2	192.6	569.3	608.1

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 97.0 хувь, төмсөөр 100.0 хувь, гурилаар 98.3 хувь, хүнсний ногоогоор 60.7 хувийг хангаж байна.

ХҮСНЭГТ 6. ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХУВЬ, эх үүсвэрээр, 2020 он

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Хэрэглээ			Хангамж	
	Хэрэглээ	Дотоодын үйлдвэрлэл	Импорт	Дотоодын	Импорт
				үйлдвэрлэл	Импорт
мянган тонн			хувь		
Мах, махан бүтээгдэхүүн	647.8	628.5	19.3	97.0	3.0
Малын мах	629.4	627.9	1.5	99.8	0.2
Загас	2.8	0.0	2.8	0.0	100.0
Шувууны мах	15.6	0.5	15.1	3.5	96.5
Сүү	1 005.1	1 005.0	0.1	100.0	0.0
Сүүн бүтээгдэхүүн	126.3	76.9	49.4	60.9	39.1

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Хэрэглээ	Дотоодын үйлдвэрлэл	Импорт	Хангамж	
				Дотоодын үйлдвэрлэл	Импорт
	мянган тонн	хувь			
Гурил, гурилан бүтээгдэхүүн	262.6	235.3	27.4	89.6	10.4
Гурил	194.5	191.1	3.4	98.3	1.7
Гурилан бүтээгдэхүүн	68.2	44.1	24.0	64.8	35.2
Төрөл бүрийн будаа	56.4	0.0	56.4	0.0	100.0
Төмс	244.3	244.3	0.0	100.0	0.0
Хүнсний ногоо	199.5	121.2	78.3	60.7	39.3
Буурцагт ургамал	0.0	0.0	0.0	98.0	2.0
Жимс, жимсгэнэ	45.8	1.6	44.1	3.6	96.4
Өндөг	16.6	8.5	8.1	51.0	49.0
Ургамлын тос	16.4	0.0	16.4	0.1	99.9
Цөцгийн тос, 72% тослогтой	0.5	0.2	0.3	48.6	51.4
Сахар, чихрийн зүйл	192.6	126.4	66.2	65.6	34.4

ХОЁР. ХҮНСНИЙ ХҮРТЭЭМЖИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний хангамж нь өрхийн түвшинд хангагдсан эсэхийг өрхийн хүнсний хүртээмжээр тодорхойлдог. Өрхийн хүнсний хүртээмжийг сэрүүний болон зуны улирлаар, хот, хөдөөгөөр тооцов.

1. Жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ

ӨНЭЗС-аар жишсэн нэг хүний хүнсний бодит улсын дундаж хэрэглээг авч үзэхэд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар, чихрийн зүйлийг улсын дунджаас давж, буурцагт ургамлыг улсын дунджийн хэмжээнд хэрэглэж байна.


ХҮСНЭГТ 7. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, грамаар, хот, хөдөөгөөр, 2020 он

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Улсын дундаж	Хот	Хөдөө
Мах, махан бүтээгдэхүүн	319.4	270.3	418.3
Малын мах	314.1	262.8	417.4
Загас	0.6	0.7	0.4
Шувууны мах	4.7	6.7	0.5
Сүү	173.8	142.6	236.5
Сүүн бүтээгдэхүүн	238.9	161.3	395.2
Гурил	173.9	121.0	280.3
Гурилан бүтээгдэхүүн	188.1	216.5	130.8
Төрөл бүрийн будаа	63.7	59.0	73.2
Төмс	93.2	97.5	84.5
Хүнсний ногоо	84.3	95.1	62.7
Буурцагт ургамал	0.2	0.2	0.0
Жимс, жимсгэнэ	33.3	39.5	20.8
Өндөг	14.6	20.0	3.6
Ургамлын тос	18.5	13.9	27.8
Цөцгийн тос, 72% тослогтой	7.2	9.3	2.9
Сахар, чихрийн зүйл	49.4	52.6	43.1

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

Зураг 2. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, граммаар 2020 он



ӨНЭЗС-ны жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ сэрүүний улиралд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар, чихрийн зүйлийг улсын дунджаас давж, буурцагт ургамлыг улсын дунджийн хэмжээнд хэрэглэж байна.

ХҮСНЭГТ 8. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, СЭРҮҮНИЙ УЛИРАЛД, граммаар, хот, хөдөөгөөр, 2020 он

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Улсын дундаж	Хот	Хөдөө
Мах, махан бүтээгдэхүүн	324.1	276.7	418.9
Малын мах	319.4	269.9	418.1
Загас	0.6	0.8	0.3
Шувууны мах	4.2	6.0	0.5
Сүү	162.4	138.5	210.1
Сүүн бүтээгдэхүүн	231.0	168.9	354.7
Гурил	177.3	125.9	279.9
Гурилан бүтээгдэхүүн	184.3	212.7	127.7
Төрөл бүрийн будаа	63.1	57.8	73.8
Төмс	94.3	98.4	86.0
Хүнсний ногоо	84.0	94.0	63.8
Буурцагт ургамал	0.2	0.2	0.0
Жимс, жимсгэнэ	31.2	37.7	18.4
Өндөг	13.9	19.2	3.4
Ургамлын тос	18.9	14.2	28.4
Цөцгийн тос, 72% тослогтой	7.3	9.4	3.1
Сахар, чихрийн зүйл	47.2	49.9	41.9

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

ӨНЭЗС-аар жишсэн нэг хүний хүнсний бодит хэрэглээ зуны улиралд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, будаа, ургамлын тосыг улсын дунджаас давж хэрэглэдэг бол хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг,

цэцгийн тос, сахар, чихрийн зүйлийг улсын дунджаас давж, буурцагт ургамлыг улсын дунджийн хэмжээнд хэрэглэж байна.

ХҮСНЭГТ 9. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, ЗУНЫ УЛИРАЛД, граммаар, хот, хөдөөгөөр, 2020 он

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Улсын дундаж	Хот	Хөдөө
Мах, махан бүтээгдэхүүн	312.8	261.4	417.5
Малын мах	306.7	252.9	416.3
Загас	0.7	0.7	0.7
Шувууны мах	5.4	7.8	0.5
Сүү	189.6	148.3	273.9
Сүүн бүтээгдэхүүн	250.1	150.7	452.7
Гурил	169.0	114.3	280.8
Гурилан бүтээгдэхүүн	193.3	221.8	135.2
Төрөл бүрийн будаа	64.5	60.6	72.4
Төмс	91.7	96.3	82.4
Хүнсний ногоо	84.9	96.5	61.1
Буурцагт ургамал	0.2	0.2	0.0
Жимс, жимсгэнэ	36.2	42.1	24.2
Өндөг	15.5	21.2	3.8
Ургамлын тос	17.9	13.4	26.9
Цэцгийн тос, 72% тослогтой	7.1	9.3	2.6
Сахар, чихрийн зүйл	52.5	56.3	44.6

Эх үүсвэр: ӨНЭЗС, ҮСХ

2. Хүнсний хүртээмж, өрхийн түвшинд

Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, будаа, төмс, сахар, чихрийн зүйлийн хүртээмж хангалттай, бусад хүнсний бүтээгдэхүүний хүртээмж хангалтгүй буюу дутагдалтай байна. Хүн амын хүнсний хэрэгцээ нь үндсэндээ мах, махан бүтээгдэхүүн, сүү, гурил зонхилон хангагдсан хэвээр байна.

ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ ХҮРТЭЭМЖ, хувиар, 2020 он


Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ	Улсын дундаж хэрэглээ			Хүртээмж		
		Улсын дундаж	Зуны улиралд	Сэрүүний улиралд	Улсын дундаж	Зуны улиралд	Сэрүүний улиралд
	грамм				хувь		
Мах, махан бүтээгдэхүүн	190.0	319.4	312.8	324.1	168.1	164.6	170.6
Малын мах	120.0	314.1	306.7	319.4	261.7	255.6	266.2
Загас	30.0	0.6	0.7	0.6	2.2	2.4	2.0
Шувууны мах	40.0	4.7	5.4	4.2	11.7	13.5	10.4
Сүү	160.0	173.8	189.6	162.4	108.6	118.5	101.5
Сүүн бүтээгдэхүүн	180.0	238.9	250.1	231.0	132.7	138.9	128.3
Гурил	100.0	173.9	169.0	177.3	173.9	169.0	177.3
Гурилан бүтээгдэхүүн	180.0	188.1	193.3	184.3	104.5	107.4	102.4
Төрөл бүрийн будаа	50.0	63.7	64.5	63.1	127.4	129.0	126.3
Төмс	120.0	93.2	91.7	94.3	77.7	76.5	78.6

Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ	Улсын дундаж хэрэглээ			Хүртээмж		
		Улсын дундаж	Зуны улиралд	Сэрүүний улиралд	Улсын дундаж	Зуны улиралд	Сэрүүний улиралд
	грамм				хувь		
Хүнсний ногоо	260.0	84.3	84.9	84.0	32.4	32.6	32.3
Буурцагт ургамал	40.0	0.2	0.2	0.2	0.4	0.4	0.4
Жимс, жимсгэнэ	200.0	33.3	36.2	31.2	16.6	18.1	15.6
Өндөг	20.0	14.6	15.5	13.9	72.8	77.4	69.4
Ургамлын тос	23.0	18.5	17.9	18.9	80.4	77.7	82.4
Цэцгийн тос, 72% тослогтой	10.0	7.2	7.1	7.3	71.8	70.5	72.8
Сахар, чихрийн зүйл	33.0	49.4	52.5	47.2	149.8	159.0	143.2

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээг улсын дундаж бодит хэрэглээтэй харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, будаа зонхилон хангагдсан хэвээр байна. Харин жимс, жимсгэнэ, хүнсний ногооны хүртээмж хангалтгүй байна.

ЗУРАГ 3. ЖИШСЭН НЭГ ХҮНД ХОНОГТ НОГДОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ, 2020 он



ГУРАВ. ХҮНСНИЙ ИЛЧЛЭГ ШИМ ТЭЖЭЭЛ

Жишсэн нэг хүний хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, найрлагыг улсын дундаж, хот, хөдөөгөөр, сэрүүн, зуны улирлаар гаргалаа.

1. Зуны улиралд

Улсын дунджаар жишсэн нэг хүний зуны улиралд хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 3111.3 килокалори, уураг 137.6 грамм, тос 71.5 грамм, нүүрс ус 481.3 грамм байгаа нь жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэгийн нормтой харьцуулахад 6.6-52.8 хувиар өндөр байна.

ХҮСНЭГТ 11. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХҮНСНЭЭС АВАХ ИЛЧЛЭГ, ШИМ ТЭЖЭЭЛ, УЛСЫН ДУНДАЖ,
хот, хөдөөгөөр, зуны улиралд

	Жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэгийн норм	Улсын дундаж		Хот		Хөдөө	
		2019	2020*	2019	2020*	2019	2020*
Илчлэг, килокалори	2 400	3 065.3	3 111.3	2 707.8	2 857.2	3 740.2	3 629.6
Уураг, грамм	90	136.7	137.6	112.0	117.9	183.3	177.7
Тос, грамм	67	72.3	71.5	53.7	56.2	107.4	102.6
Нүүрс ус, грамм	360	468.9	481.3	444.7	470.6	514.4	503.1

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

Судалгааны үр дүнгээр, бодитойгоор гарсан жишсэн нэг хүний хоногт хүнснээс авсан илчлэг, шим тэжээлийн хэмжээ нь жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах ёстой илчлэг, шим тэжээлийн нормоос давсан байна. Харин жишсэн нэг хүний хоногт хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн хэмжээ хот, хөдөөд харилцан адилгүй байна.

Хотын хүн амын хүнснээс авах тосны хэмжээ физиологийн түвшнээс бага, хөдөөд хүнснээс авах илчлэг, уураг, тос, нүүрс усны илчлэг нормоос давсан байна.

1. Сэрүүний улиралд

Улсын дунджаар жишсэн нэг хүний сэрүүний улиралд хүнсний бүтээгдэхүүнээс авсан илчлэг 3056.9 килокалори, уураг 137.2 грамм, тос 70.5 грамм, нүүрс ус 469.9 грамм байгаа нь жишсэн нэг хүний хүнснээс авах нормтой харьцуулахад илчлэг, нүүрс ус, уургийн хэмжээ нормоос 5.3-52.5 хувиар их байна.

Сэрүүний улиралд хотод хүн амын хүнснээс авах илчлэг, уураг, нүүрс усны хэмжээ их, тосны хэмжээ физиологийн нормын түвшнээс бага, хөдөөд илчлэг, уураг, тос, нүүрс усны хэмжээ нормоос давсан байна.

ХҮСНЭГТ 12. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХҮНСНЭЭС АВАХ ИЛЧЛЭГ, ШИМ ТЭЖЭЭЛ, УЛСЫН ДУНДАЖ,
хот, хөдөөгөөр, сэрүүний улиралд

	Жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэгийн норм	Улсын дундаж		Хот		Хөдөө	
		2019	2020*	2019	2020*	2019	2020*
Илчлэг, килокалори	2 400	2 930.3	3 056.9	2 717.0	2 870.3	3 343.5	3 429.2
Уураг, грамм	90	131.5	137.2	115.3	121.4	163.0	168.9
Тос, грамм	67	66.4	70.5	55.3	58.8	87.8	93.9
Нүүрс ус, грамм	360	453.4	469.9	440.3	464.5	478.8	480.9

Эх үүсвэр: ӨНЭЗС, УСХ

ДӨРӨВ. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. Хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин

МХЕГ-ын Хяналтын итгэмжлэгдсэн лабораториудын нэгдсэн сүлжээний хэмжээгээр 2020 оны байдлаар хүнсний хими, нян судлал, хор судлал, ургамал хорио цээр, цацрагийн бохирдлын чиглэлээр 310.5 мянган үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 6.7 мянган сорьц MNS шаардлага хангаагүй, бохирдлын түвшин 2.1 хувь байна.

2. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн

МХЕГ-ын хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан бүтээгдэхүүний хэмжээг дараах хүснэгтээр харуулав. Хяналт, шалгалтаар хураасан бүтээгдэхүүнийн хэмжээ 14.8 мянган кг болж, өнгөрсөн оноос 11.9 (5.1 дахин) мянган кг-аар, устгасан бүтээгдэхүүний хэмжээ 3.1 мянган кг болж, 147.9 (5.1%) кг-аар, 63.8 мянган ширхэг болж, 1.4 (2.3%) мянган ширхэгээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 13. ХЯНАЛТ, ШАЛГАЛТААР ХУРААСАН, БУЦААСАН, ТАТАН АВСАН, УСТГАСАН ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
Хураасан бүтээгдэхүүн	килограмм	5 572.5	425.3	2 891.0	14 782.2	5.1'
	литр	1 574.0	489.8	1 937.6	1 343.0	-30.7
	ширхэг	42 010	20 082	65 825	55 077	-16.3
Буцаасан бүтээгдэхүүн	килограмм	781.7	1 443.4	508.4	198.8	-60.9
	литр	214.0	440.3	115.5	-	-100.0
	ширхэг	12 573	3 659	7 879	2 222	-71.8
Татан авсан бүтээгдэхүүн	килограмм	611.7	3 012.7	1 518.0	60.0	-96.0
	литр	64.0	84.0	120.0	66.5	-44.6
	ширхэг	6 030.0	36 151.0	11 874.0	1 593.0	-86.6
Устгасан бүтээгдэхүүн	килограмм	8 396.6	12 989.4	2 910.5	3 058.4	5.1
	литр	1 546.1	523.3	2 023.7	1 267.0	-37.4
	ширхэг	39 552	67 755	62 319	63 764	2.3

Эх үүсвэр: МХЕГ

' Дахин их

3.Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн ААНБ, иргэдийн тоо

МХЕГ-аас явуулсан хяналт, шалгалтад нийт 15.2 мянган ААНБ, 6.7 мянган иргэд хамрагдаж, өмнөх оны зөрчил гаргасан ААНБ-ын тоо 6-гаар буурч, харин иргэдийн тоо 14-оор нэмэгдсэн бол, 20 ААНБ, 38 иргэдийн үйл ажиллагааг сэргээсэн байна.

ХҮСНЭГТ 14. ХЯНАЛТАД ХАМРАГДСАН, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООСОН, СЭРГЭЭСЭН ААНБ, ИРГЭДИЙН ТОО

Үзүүлэлт	2017		2018		2019		2020	
	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд
Хяналтад хамрагдсан	5 290	4 850	6 188	4 744	9 166	8 944	15 179	6 711
Үйл ажиллагааг түр зогсоосон	81	49	51	32	37	27	31	49
Үйл ажиллагааг сэргээсэн	45	19	19	29	22	19	20	38

Эх үүсвэр: МХЕГ

Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчил

МХЕГ-аас явуулсан хяналт, шалгалтаар нийт 42.2 мянган зөрчил илрүүлснээс 68.6 хувь буюу 29.0 мянган зөрчлийг арилгуулсан байна.

ХҮСНЭГТ 15. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН БОЛОН АРИЛГУУЛСАН ЗӨРЧИЛ

Үзүүлэлт	2019		2020	
	Илрүүлсэн зөрчлийн тоо	Арилгуулсан зөрчлийн тоо	Илрүүлсэн зөрчлийн тоо	Арилгуулсан зөрчлийн тоо
Бүгд	33 093	24 600	42 195	28 964
Барилга, байгууламжийн норм дүрмийн	3 727	2 190	3 696	2 144
Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн	3 200	2 141	4 073	2 728
Технологийн үйл ажиллагааны	2 585	1 897	3 898	3 049
Ариун цэвэр, эрүүл ахуйн	6 145	4 844	5 559	3 864
Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын	3 584	2 842	5 295	3 862
Хадгалалт, тээвэрлэлтийн	4 184	3 303	5 370	3 246
Сав, баглаа, боодол, хаяг, шошгын	3 841	2 801	5 389	3 443
Дотоодын хяналтын	5 927	4 578	8 915	6 628

Эх үүсвэр: МХЕГ

Илрүүлсэн зөрчлийн 21.1 хувийг дотоодын хяналтын, 13.2 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн, 12.8 хувийг сав, баглаа, боодол, хаяг, шошгын, 12.7 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн, 12.5 хувийг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын, 9.7 хувийг ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн, 9.2 хувийг технологийн үйл ажиллагааны, 8.8 хувийг барилга, байгууламжийн норм дүрмийн зөрчил эзэлж байна. Харин эдгээр зөрчил тус бүрийн 58.0-78.2 хувийг арилгуулжээ.

4. Хүнсний бүтээгдэхүүнд сорилт, шинжилгээ хийх эрх бүхий итгэмжлэгдсэн лабораторийн тоо

Хүнсний бүтээгдэхүүний сорилт гүйцэтгэж байгаа 106 лаборатори үйл ажиллагаа явуулж, өнгөрсөн оноос 37 (34.9%)-гоор нэмэгдсэн байна.

5. Хүнсний холбогдолтой үндэсний, олон улс, бүс нутаг, гадаад орны стандарт болон техникийн зохицуулалт

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар хүнсний салбарт дараах техникийн зохицуулалтыг мөрдөж байна. Үүнд:

1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт, МУЗГ-ын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 159 дүгээр тогтоол;
2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техникийн зохицуулалт, МУЗГ-ын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 304 дүгээр тогтоол;
3. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохицуулалт, МУЗГ-ын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 305 дугаар тогтоол;
4. Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны 64 дүгээр тушаал;


Хүнсний холбогдолтой үндэсний стандартын тоо 2020 онд 693 болж өмнөх оноос 25 (3.7%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 16. ХҮНСНИЙ ХОЛБОГДОЛТОЙ ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫН ТОО

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
Нийт стандартын тоо	648	662	666	668	693	3.7
Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн стандарт	256	262	264	264	272	3.0
Уялдуулсан стандарт	392	400	402	404	421	4.2

Эх үүсвэр: СХЗГ

ЗУРАГ 4. ХҮНСНИЙ ХОЛБОГДОЛТОЙ НИЙТ БОЛОН ОУ, БҮС НУТАГ, ГАДААД ОРНЫ ДЭВШИЛТЭТ СТАНДАРТЫН ТҮВШИНД ХҮРСЭН СТАНДАРТЫН ТОО



Үндэсний 693 стандарт мөрдөж байгаагаас 272 буюу 39.2 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн, 421 буюу 60.8 хувь нь уялдуулсан стандарт байна.

6. Тохирлын үнэлгээнд хамрагдсан ААНБ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл

Хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 110 ААНБ тохирлын үнэлгээнд хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 62 ААНБ буюу 36.0 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 17. ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН ААНБ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ

Үзүүлэлт	2016		2017		2018		2019 ¹		2020	
	ААНБ-ын тоо	Бүтээг-дэхүүний төрөл	ААНБ-ын тоо	Бүтээг-дэхүүний төрөл	ААНБ-ын тоо	Бүтээг-дэхүүний төрөл	ААНБ-ын тоо	Бүтээг-дэхүүний төрөл	ААНБ-ын тоо	Бүтээг-дэхүүний төрөл
Бүгд	165	755	153	668	115	458	172	325	110	278
Импортын бүтээгдэхүүний баталгаажуулалт	115	335	97	301	55	85	65	76	79	5
Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний баталгаажуулалт	42	400	49	319	53	325	94	150	24	226
"Аюулгүйн тэмдэг"-ийн баталгаажуулалт ¹	8	20	7	48	7	48	13	99	7	47

Эх үүсвэр: СХЗГ

¹ Үндэсний тохирлын тэмдгийг 2019 оноос ашиглахаа больж "Аюулгүйн тэмдэг" ашигладаг болсон.

Тохирлын үнэлгээнд хамрагдаж баталгаажуулалт хийгдсэн нийт 278 төрлийн бүтээгдэхүүн байна. Үүний 1.8 хувьд нь импортын бүтээгдэхүүний баталгаажуулалт, 81.3 хувьд нь дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний баталгаажуулалт, 16.9 хувьд нь "Аюулгүйн тэмдэг"-ийн баталгаажуулалт хийгджээ.

7. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн гэрчилгээ олгогдсон буюу Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг нэвтрүүлсэн хүнсний салбарын 20 ААНБ байна.

8. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрийн тоо

Эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 22 ААНБ байгаагаас 12 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000 стандартыг, 10 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо /НАССР/ нэвтрүүлсэн байна. Харин хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлсэнг баталгаажуулсан нэг ч ААНБ байхгүй нь уг баталгаажуулалтыг хийх тогтолцоо манай улсад хараахан бүрдээгүйтэй холбоотой.

ХҮСНЭГТ 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЗОХИСТОЙ ДАДАЛ, АЮУЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЭГЗЭГТЭЙ ЦЭГИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСЭН ҮЙЛДВЭРИЙН ТОО

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
Нийт үйлдвэрийн тоо	5	7	11	19	22	15.8
Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000 стандартыг нэвтрүүлсэн	3	3	5	10	12	20.0
Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо /НАССР/ нэвтрүүлсэн	2	4	6	9	10	11.1
Зохистой дадал нэвтрүүлсэн	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: СХЗГ

9. Баяжуулсан хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрийн тоо, үйл ажиллагааны төрлөөр

Давс олборлох зөвшөөрөлтэй, тогтмол үйл ажиллагаатай 8 ААНБ байгаагаас дотоодын үйлдвэрлэлийн давсыг иоджуулж, савлах 4 ААНБ тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

10. Баталгаат ундны усаар хангагдаж буй хүн амын тоо

Хүн ам, орон сууцны тооллогын 2020 оны дүнгээр Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 84.0 хувь буюу 2 685.5 мянган хүн шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс ундны усаар хангагдаж байна.

11. Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэрийн тоо

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй спиртийн 6, архины 26, дарсны 8, шар айргийн 12 үйлдвэр байна.

12. Нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ

Нэг хүнд ногдох архи 2020 оны байдлаар 8.1 литр болж, өнгөрсөн оноос 0.8 (9.9%) литрээр, дарс 0.8 литр болж, 0.2 (16.9%) литрээр буурсан бол, шар айраг 30.6 литр болж, 0.3 (1.0%) литрээр өссөн байна.

ХҮСНЭГТ 19. НЭГ ХҮНД НОГДОХ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭМЖЭЭ

	2016	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
	литр					
Архи	8.1	8.3	9.6	8.9	8.1	-9.9
Дарс	0.7	0.9	1.0	1.0	0.8	-16.9
Шар айраг	30.2	28.4	31.1	30.3	30.6	1.0

Эх үүсвэр: ҮСХ

2020 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны нэг хүнд ногдох архи 11.9 литр болж, 2 (9.1%) литрээр, дарс 1.2 литр болж, 0.2 (15.4%) литрээр буурсан бол, шар айраг 45.3 литр болж, 0.9 (1.9%) литрээр өссөн байна.

ХҮСНЭГТ 20. 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ НЭГ ХҮНД НОГДОХ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭМЖЭЭ

	2016	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
	литр					
Архи	11.4	11.7	13.9	13.1	11.9	-9.1
Дарс	0.9	1.2	1.5	1.4	1.2	-15.4
Шар айраг	42.3	40.2	44.9	44.4	45.3	1.9

Эх үүсвэр: ҮСХ

13. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт болон өвчилсөн хүний тоо, үүнээс эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, нас барсан хүний тоо

Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гэж ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг өвчний гурав ба түүнээс олон тохиолдол илрэхийг ойлгоно.

Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 12 дэгдэлт бүртгэгдэж, өнгөрсөн оноос 2 (14.3%)-оор буурсан байна. Дэгдэлтээр нийт 205 хүн өвдөж, 95 хүн эмнэлэгт хэвтэн, 110 хүн гэрээр өрхийн эмчийн хяналтад эмчлэгдсэн ба нян судлалын шинжилгээгээр 205 хүнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн байна.

Засгийн газраас зарласан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал” зарласантай холбоотой хоол хүнсээр дамжих өвчнөөр өвчилсөн хүний тоо өнгөрсөн оноос 1083 (84.1%) хүнээр, эмнэлэгт хэвтсэн хүний тоо 262 (73.4%) хүнээр тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 21. ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТ, ӨВЧИЛСӨН, ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛСЭН БОЛОН НАС БАРСАН ХҮНИЙ ТОО

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020 ¹	Өсөлт, бууралт, %
Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо	12	5	20	14	12	-14.3
Өвчилсөн хүний тоо	382	118	624	1 288	205	-84.1
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	127	98	263	357	95	-73.4
Амь насаа алдсан хүний тоо	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: ЭМЯ

¹ Нийт хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоонд химийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогын дүн ороогүй болно.

ЗУРАГ 5. ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИХ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТ, ӨВЧИЛСӨН ХҮНИЙ ТОО



ХҮСНЭГТ 22. НЯНГИЙН ГАРАЛТАЙ ХООЛ ХҮНСНЭЭС ШАЛТГААЛСАН ХОРДЛОГОТ ХАЛДВАРТ ӨВЧЛӨЛ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Өсөлт, бууралт, %
Өвчилсөн хүний тоо	430	133	554	153	205	34.0
Хот	386	89	328	109	125	14.7
Хөдөө	44	44	226	44	80	81.8

Эх үүсвэр: ЭМЯ

ТАВ. ДҮГНЭЛТ

- ◁ Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг 4 бүлэгт хуваан тооцон гаргалаа. Жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, махан бүтээгдэхүүн 182.4 мян.тн, сүү 153.6 мян.тн, гурил, гурилан бүтээгдэхүүн 268.8 мян.тн, төмс 115.2 мян.тн хэрэгцээтэй байна.
- ◁ Хүн амын хүнсний хангамжийн хувийг гол нэр төрлийн 16 бүтээгдэхүүнээр тооцсон бөгөөд зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг авч үзвэл мах, махан бүтээгдэхүүний 97.0 хувийг дотоодын үйлдвэрээс, 3.0 хувийг импортоос, сүүний 100.0 хувийг дотоодын үйлдвэрээс, гурил, гурилан бүтээгдэхүүний 89.6 хувийг дотоодын үйлдвэрээс, 10.4 хувийг импортоос, хүнсний ногооны 60.7 хувийг дотоодын үйлдвэрээс, 39.3 хувийг импортоос тус тус нийлүүлсэн байна.
- ◁ 2020 оныг өнгөрсөн онтой харьцуулахад буурцагт ургамлын үйлдвэрлэл 63.9 хувь, жимс, жимсгэний үйлдвэрлэл 11.0 хувь, өндөгний үйлдвэрлэл 5.1 хувь, ургамлын тосны үйлдвэрлэл 93.4 хувиар тус тус буурсан бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүдийн хүртээмж хүн амын хэрэгцээнд хангалтгүй байсаар байна.
- ◁ Хүнсний хүртээмж хот, хөдөөгийн хэмжээнд харилцан адилгүй байдаг бөгөөд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, ургамлын тосыг улсын дунджаас давж, хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар чихрийн зүйлийг улсын дунджаас давж хэрэглэж байна.
- ◁ Хүнсний ногоо, буурцагт ургамал, жимс, жимсгэний хүртээмж хангалтгүй байгаа нь жишсэн нэг хүний хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн улсын дундаж хэмжээ нормоос давсан шалтгаанд нөлөөлж байна.
- ◁ МХЕГ-ын мэдээлснээр хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах итгэмжлэгдсэн эрх бүхий 106 лабораториуд үйл ажиллагаа явуулдаг. 2020 онд 42.2 мянган зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оноос 9.1 (27.5%) мянган зөрчлөөр нэмэгдсэн байна.
- ◁ СХЗГ-ын мэдээлснээр чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг нэвтрүүлсэн 20 ААНБ, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000 стандартыг нэвтрүүлсэн 12 үйлдвэр, эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянах шинжлэх тогтолцоо HACCP стандартыг нэвтрүүлсэн 10 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.
- ◁ ЭМЯ-ны мэдээлснээр өнгөрсөн оноос хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт 14.3 хувиар, өвчилсөн хүний тоо 84.1 хувиар, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 73.4 хувиар тус тус буурсан бөгөөд энэ нь 2020 онд гарсан ковид 19-ийн цар тахал, Засгийн газрын гамшгаас хамгаалах шийдвэрүүдтэй холбоотой юм.

ХАВСРАЛТ 1. ТООЦООЛОЛД АШИГЛАСАН ИТГЭЛЦҮҮР, НОРМ, СТАНДАРТ

ХҮСНЭГТ 1. ЖИШСЭН ХҮНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР, 2020 ОН

Д/д	Насны бүлэг	Хүйс	Шилжүүлэх итгэлцүүр
А	Б	В	1
1	1 хүртэлх нас	эр	0.34
2		эм	0.31
3	1-3 нас	эр	0.44
4		эм	0.41
5	4-6 нас	эр	0.61
6		эм	0.55
7	7-10 нас	эр	0.76
8		эм	0.69
9	11-14 нас	эр	1.04
10		эм	0.90
11	15-18 нас	эр	1.13
12		эм	0.95
13	19-29 нас	эр	1.00
14		эм	0.83
15	30-59 нас	эр	0.99
16		эм	0.77
17	60-аас дээш нас	эр	0.80
18		эм	0.70

ХҮСНЭГТ 2. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХОНОГИЙН БОЛОН ЖИЛИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭНИЙ НОРМ, биет хэмжээгээр

Д/д	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ, кг	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ, кг
А	Б	1	2
1	Малын мах	0.120	43.8
2	Загас	0.030	11.0
3	Шувууны мах	0.040	14.6
4	Сүү	0.160	58.4
5	Сүүн бүтээгдэхүүн	0.180	65.7
6	Гурил	0.100	36.5
7	Гурилан бүтээгдэхүүн	0.180	65.7
8	Төрөл бүрийн будаа	0.050	18.3
9	Сахар, чихрийн зүйл	0.033	12.0
10	Төмс	0.120	43.8
11	Хүнсний ногоо	0.260	94.9
12	Жимс, жимсгэнэ	0.200	73.0
13	Буурцагт ургамал	0.040	14.6
14	Өндөг	0.020	7.3
15	Ургамлын тос	0.023	8.4
16	Цөцгийн тос	0.010	3.7

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 02-р сарын 23-ны өдрийн
А/74 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

**ХҮСНЭГТ 3. ЖИШСЭН НЭГ ХҮНИЙ ХОНОГИЙН ХҮНСНИЙ
ИЛЧЛЭГИЙН НОРМ**

		Жишсэн нэг хүний хоол хүнснээс хоногт авах илчлэг, ккал*	Шимт бодисууд, (гр)						Нүүрс ус
			Уураг	Үүнээс:		Тос	Үүнээс:		
				Амьтны	Ургамлын		Амьтны	Ургамлын	
А	Б	1	2	3	4	5	6	7	8
Малын мах	1	180	19	19		12	12		
Загас	2	60	5	5		4	4		
Шувууны мах	3	63	8	8		3	3		
Сүү	2	95	5	5		5	5		8
Сүүн бүтээгдэхүүн	3	102	5	5		6	6		7
Гурил	4	357	13		13	1		1	74
Гурилан бүтээгдэхүүн	5	575	14		14	2		2	125
Төрөл бүрийн будаа	6	140	4		4	0		0	31
Төмс	7	108	2		2	0		0	24
Хүнсний ногоо	8	85	3		3	0		0	18
Буурцагт ургамал	9	119	8		8	1		1	20
Жимс, жимсгэнэ	10	82	1		1	0		0	20
Өндөг	11	32	3	3	0	2		2	0
Ургамлын тос	12	207				23		23	
Цөцгийн тос	13	66				7	7		
Сахар, чихрийн зүйл	14	128				0			33
Бүгд		2400	90	45	45	67	37	30	360

**ГОЛ НЭРИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НЭГ БҮТЭЭГДЭХҮҮНД
ШИЛЖҮҮЛЭН ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР**

ХҮСНЭГТ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТУРАГ МАХАНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
1.1	Таван хошуу малын мах	1.0
1.2	Гахай, шувуу болон загасны мах	1.0
1.3	Ангийн мах (зэрлэг ан амьтдын мах)	1.0
1.4	Чанамал хиам	1.1
1.5	Чанамал, утлагат хиам	1.4
1.6	Түүхий утлагат хиам	2.6
1.7	Дотор мах	1.4
1.8	Махан консерв	1.3
1.9	Борц	5.7
1.10	Загасны консерв	1.57

ХҮСНЭГТ 5. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШИНГЭН СҮҮНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
2.1. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн:		
2.1.1.	Ундны сүү *	1.0
2.1.2	Хуурай сүү (25%-ийн тостой)	8.6
2.1.3	Өтгөрүүлсэн сүү	2.7
2.1.4	Исгэлэн сүүн бүтээгдэхүүн* (тараг, кефир, йогурт, г.м)	1.0
2.1.5	Аарц (9%-ийн тостой)	6.7
2.1.6	Цөцгий, зөөхий (25%-ийн тостой)	7.8
2.1.7	Бяслаг	8.8
2.1.8	Цөцгийн тос (72%-ийн тостой)	22.5
2.1.9	Ааруул	10.0
2.2. Уламжлалт аргаар үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүн:		
2.2.1	Исэг цагаан идээ (тараг, айраг, хоормог)	1.0
2.2.2	Шар тос	25.0
2.2.3	Өрөм	16.7
2.2.4	Эзэгий	13.0

Тайлбар: * - түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тос агууламж 1:1 байна.

ХҮСНЭГТ 6. ГУРИЛ, ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ГУРИЛД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
3.1	Буудайн гурил	1.0
3.2	Хөх тарианы гурил	1.0
3.3	Бусад тарианы гурил	1.0

3.4	Бүх төрлийн талх	0.74
3.5	Чанамал гурилан бүтээгдэхүүн	0.65
3.6	Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн	0.60
3.7	Жигнэмэг	0.60
3.8	Өрмөнцөр	0.25
3.9	Бялуун бүтээгдэхүүн	0.15
3.10	Гоймон	1.0

ХҮСНЭГТ 7. ТӨРӨЛ БҮРИЙН БУДААГ НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
4.1	Цагаан будаа	1.0
4.2	Гурвалжин будаа	1.0
4.3	Шар будаа	1.0
4.4	Бусад будаа	1.0

ХҮСНЭГТ 8. САХАР, ЧИХРИЙН ЗҮЙЛИЙГ САХАРТ ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
5.1	Элсэн чихэр	1.0
5.2	Ёотон	1.0
5.3	Хатуу чихэр	0.96
5.4	Шоколад, зөөлөн чихэр, зефир	0.46
5.5	Жимсний чанамал, сироп	0.46
5.6	Хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа	0.47

ХҮСНЭГТ 9. ТӨМС, ТӨМСНИЙ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШИНЭ ТӨМСӨНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
6.1	Шинэ төмс	1.0
6.2	Шарсан савханцар төмс (French fries)	2.0
6.3	Чипс	4.0
6.4	Төмсний нухаш (усанд найруулж хэрэглэхэд бэлэн болгосон)	8.5
6.5	Төмсний цардуул, пүнтүүз	10.0

ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ НОГООГ ШИНЭ НОГООНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
7.1	Үндэс үрт ногоо (шар лууван, цагаан лууван, улаан лууван, хүрэн, шар, сармаг манжин, тонх, гич, үндэс үрт яншуй, үндэс үрт цоор, үндэс үрийн гич)	1.0
7.2	Сонгинолог булцуу үүсгэдэг ногоо (бөөрөнхий сонгино, тагар сонгино, урт сонгино, порей сонгино, саримс, гэх мэт)	1.0
7.3	Үр жимст ногоо (лооль, цэс, чинжүү, өргөст хэмх, хулуу, амтат гуа, тарвас)	1.0
7.4	Навчит ногоо (навчит байцаа, хятад байцаа, бууцай, навчит салат, хүнхээл, жууцай гэх мэт)	1.0
7.5	Цэцэгт ногоо (цэцэгт байцаа, брокколи, артишок гэх мэт)	1.0
7.6	Толгой үүсгэдэг: Бөөрөнхий байцаа, савайн байцаа, олон толгойт байцаа, бөөрөнхий салат	1.0
7.7	Үнэрт ба амтлагч ногоо: гоньд, яншуй, цоохор майлз, үсүү, цоор	1.0
7.8	Нөөшилсэн ногоо	1.3
7.9	Хөлдөөсөн ногоо	1.3
7.10	Хатаасан ногоо, мөөг	9.0
7.11	Кетчуп	2.48
7.12	Лоолийн шүүс	1.64
7.13	Мөөг	1.0
7.14	Нөөшилсэн мөөг	1.25

ХҮСНЭГТ 11. ЖИМС, ЖИМСГЭНИЙГ ШИНЭ ЖИМСЭНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
8.1	Үрт жимс (алим, лийр, долоогоно, тэс, ирга, гадир, хеномелес, кавказ, илжгэн чих гэх мэт)	1.0
8.2	Яст жимс (интоор, чинтоор, тоор, гүйлс, шинэ чавга, туйван гэх мэт)	1.0
8.3	Байгалийн (зэрлэг) болон таримал (чацаргана, гүзээлзгэнэ, үхэр нүд гэх мэт)	1.0
8.4	Цитрусын төрлийн жимс (амтат жүрж, бэрсүүт жүрж, нимбэг гэх мэт)	1.0
8.5	Бусад жимс	1.0
8.6	Хатаасан жимс, жимсгэнэ	3.23-5.0
8.7	Нөөшилсэн жимс, жимсгэнэ	0.85
8.8	Жимсний шүүс, сок	0.7
8.9	Компот	0.68

ХҮСНЭГТ 12. БУУРЦАГТ УРГАМЛЫГ НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
9.1	Вандуй, шош, шар буурцаг	1.0
9.2	Дүүфүү	0.6
9.3	Нөөшилсөн вандуй, шош	1.3

ХҮСНЭГТ 13. ӨНДӨГ, ӨНДӨГНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШИНЭ ӨНДГӨНД ШИЛЖҮҮЛЭХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Нэр төрөл	Шилжүүлэх итгэлцүүр
10.1	Тахианы шинэ өндөг	1.0
10.2	Бусад шувууны өндөг	1.0
10.3	Хуурай өндөг	24.84

ХАВСРАЛТ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 1. СУУРИН ХҮН АМ

Насны бүлэг	Хүйс	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд		2 555 209	2 588 214	2 623 483	2 653 828	2 704 526	2 760 605	2 823 137
